



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/10

Улаанбаатар хот

Өмч хамгаалах байнгын зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1,2, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” А/155 дугаар захирамжаар батлагдсан газрын дүрмийн 7.1.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга

Гишүүд: Маркетинг сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Хүний нөөц, ёс зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Архив, бичиг хэргийн эрхлэгч

Ахлах нягтлан бодогч

Агентлаг хариуцсан нярав

Нарийн бичгийн

дарга: Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүд хариуцсан менежер

2. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдийг мэргэжлийн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг зөвлөлийн дарга /Х.Содномдэмбэрэл/-д даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2019 оны А/11 дүгээр тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГА *D. Batsoo* Д. БАТСҮХ



1150500046